



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 4/468

Чингис хот

Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а" Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.2, 70.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны нөхөн сонгуулийн санал авах ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахтай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулах, 2021 оны 10 дугаар сарын 10-ний өдөр гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллахыг тус тус хориглосугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг мэдээллээр хангаж, захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа Б.Батсайхан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231012233